

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавар нийт 76 оноотой. Даалгавар бүр 5 сонгох хариулттай бөгөөд зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай. Амжилт хүсье.

1. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

a. 2.5-1.5 сая жилийн өмнө – Хомо хабилис

b. 40000 жилийн өмнө – Монголд.....?

- | | | |
|-----------------|-------------------------|-----------------|
| A. Хомо эректус | B. Австралопитек | C. Хомо сапиенс |
| D. Неандерталь | E. Хомо сапиенс сапиенс | |

2. Эртний хүмүүсийн амьдралд гарсан дэвшил, ололтыг чулуун зэвсгийн үечлэлээр нь төгсгөлөөс эхлэл рүү зөв эрэмбэлсэн хариултыг олно уу. (2 оноо)

1. Нум сум

2. Хэл яриа

3. Гал

- | | | | | |
|------------|------------|------------|------------|------------|
| A. 1, 2, 3 | B. 3, 2, 1 | C. 2, 1, 3 | D. 3, 1, 2 | E. 2, 3, 1 |
|------------|------------|------------|------------|------------|

3. Монголын неолитын үед гарсан дэвшил аль нь вэ? (1 оноо)

- | | | |
|----------------|-------------------------|---------------------------|
| A. Бичиг үсэг | B. Нүүдлийн мал аж ахуй | C. Төмөрлөг боловсруулалт |
| D. Хадны зураг | E. Үйлдвэрлэх аж ахуй | |

4. НТӨ XIV-VIII зуунд холбогдох дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн нүүдэлчдийн дурсгал аль нь вэ? (1 оноо)

- | | | |
|------------------|-------------------|----------------|
| A. Хиргисүүр | B. Дөрвөлжин булш | C. Буган хөшөө |
| D. Түүвэр олдвор | E. Чандманы соёл | |

5. НТӨ 2350 онд хоёр мөрний бүх нутгийг нэгтгэж, Аккадын хаант улсыг үндэслэн байгуулсан хаан хэн бэ? (1 оноо)

- | | | | | |
|----------------|-------------|--------------|------------------|--------------|
| A. Ашурбанипал | B. I Саргон | C. Хаммурапи | D. Навуходоносор | E. II Саргон |
|----------------|-------------|--------------|------------------|--------------|

6. Он тооллын шугамыг анхааралтай ажиглан, доорх асуултад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)



a. Дунд Египет хэдэн жил оршин тогтносон бэ?

b. Дунд Египет хэдээс хэддүгээр зуунд оршин тогтнож байсан бэ?

- | | |
|--|-------------------------------------|
| A. a. 810 жил, b. НТӨ XXI-IV зуун | B. a. 4960 жил, b. НТӨ XXIX-IV зуун |
| C. a. 4925 жил, b. НТӨ XVI-XI зуун | D. a. 480 жил, b. НТӨ XXI-XVI зуун |
| E. a. 1569 жил, b. НТӨ XXVIII-XXI зуун | |



7. Хүснэгтийг ажиглан эртний Энэтхэг улсад холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Газар нутаг	2. Түүхэн зүтгэлтэн	3. Улс
a. Инд мөрөн	a. Рамзес	a. Ассирын эзэнт гүрэн
b. Нил мөрөн	b. Менэс	b. Маурын эзэнт гүрэн
c. Шар мөрөн	c. Ашока	c. Шан улс

A. 1b, 2c, 3b B. 1b, 2c, 3a C. 1a, 2a, 3c D. 1c, 2b, 3c E. 1a, 2c, 3b

8. “Уди хаан, энх ургийн гэрээ, түүхэн тэмдэглэл” хэмээх ойлголтууд нь эртний Хятадын ямар улсад холбогдох вэ? (1 оноо)

A. Хан B. Шан C. Жоу D. Ся E. Цинь

9. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу. (1 оноо)

Эртний Ромын иргэншил нь газар дундын тэнгисийн дунд хойгийн төв хэсэгт Тибер голын хөвөөнд бий болжээ.

A. Аппениний B. Балканы C. Скандинавын D. Солонгосын E. Энэтхэг, Хятадын

10. Эртний Грекийн түүхэнд холбогдох үйл явдлуудыг он цагийн зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

1. Александр Персийн эзэнт гүрнийг ялав.

2. Анхны олимп зохиогдов.

3. Пелопоннесын дайн болов.


A. 2, 1, 3 B. 3, 2, 1 C. 1, 2, 3 D. 2, 3, 1 E. 3, 1, 2

11. Хүннү гүрний хойд хил хязгаар хаана хүрч байсан бэ? (1 оноо)

A. Алтайн нуруу B. Хянганы нуруу C. Цагаан хэрэм D. Байгал нуур E. Дорнод Туркестан

12. Он тооллын шугамыг ашиглан зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

2026 онд “Үндэсний их баяр наадам”-аар Монголын тулгар төр байгуулагдсаны хэдэн жилийн ойг тэмдэглэх вэ?




A. 1817 жил B. 2235 жил C. 302 жил D. 2119 жил E. 819 жил

13. Хятан гүрний захиргаанаас гарах зорилготой хамгийн том бослого нь 1113 онд эхэлсэн Зүрчидийн бослого байв. Энэхүү түүхэн цаг хугацаа нь хэддүгээр мянганд хамаарах вэ? (1 оноо)

A. III мянганы I хагас B. I мянганы II хагас C. I мянганы I хагас
D. II мянганы II хагас E. II мянганы I хагас



14. Монгол нутагт байгуулагдсан эртний төрт улсын он тооллын шугамыг анхааралтай ажиглан, доорх асуултад тохирох хариултыг сонгоно уу. (2 оноо)



- A. а. Түрэг, б. Пэйло B. а. Монгол, б. Таньшихуай C. а. Түрэг, б. Буман
D. а. Монгол, б. Чарагуй E. а. Монгол, б. Амбагян

15. Анх амьтны загварт урлаг ямар улсад өндөр түвшинд хөгжсөн бэ? (1 оноо)

- A. Түрэг B. Сяньби C. Жужан D. Хүннү E. Уйгур

16. Монголын эртний улсуудын аж ахуй, соёлын ололтуудаас Хятан улсын үед хамаарах хариултыг зөв сонгоно уу? (1 оноо)

1. Их, бага бичиг 2. Хоёр ёс 3. Төмөр дөрөө 4. Ахын дуу 5. Тариалангийн хууль

- A. 3, 5 B. 1, 2 C. 1, 5 D. 2, 3 E. 2, 4

17. Франк улс ямар хааны үед хүчирхэгжилтийн оргил үедээ хүрсэн бэ? (1 оноо)


- A. Их Карл B. Хлодвиг C. Карл Мартелл D. Намхан Пипин E. Немец Людвиг

18. Доорх сурвалжийн мэдээ нь дундад зууны өрнө дахины ямар улсын тухай өгүүлж байна вэ? (2 оноо)

“Дэлхийн нэг ч сүмд ийм баялгийг олж харахгүй биз ээ. Сүмийн дотор баганат танхим, тоо томшгүй олон алт, мөнгөөр хийсэн зул асааж, ордны дэргэд зугаа цэнгэлийн газар – морин тойруулга бий”/ 1117 оны 12 сард Константинополь хотод айлчилсан Туделийн Вениаминий тэмдэглэлээс/

- A. Византын эзэнт улс B. Орос улс C. Франк улс D. Вандаулс E. Зүүн Гот улс

19. Бүдүүвчийг ажиглан зүүн славянд хамаарах өнөөгийн улсыг сонгоно уу. (1 оноо)



- A. Польш B. Беларусь C. Чех D. Эстони E. Словак



20. Дундад зууны үеийн Майя, Ацтек, Инк зэрэг улсуудтай холбогдох **a, b** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? (2 оноо)

a. Теночтитлан, Куско, Чичен - Ица

b. Нарны хуанли, одон орон, бичиг үсэг, сургууль

A. a. Нийслэл хот, b. аж ахуй

B. a. Байгаль газар зүй, b. соёлын хөгжил

C. a. Газар нутаг, b. ач холбогдол

D. a. Нийслэл хот, b. соёлын ололт

E. a. Эх сурвалж, b. соёлын ололт

21. Мэдээллийг уншиж, тохирох түлхүүр үгийг сонгоно уу. (2 оноо)

618 онд Ли Юань жанжин 6 жилийн дотор бүх хятадыг нэгтгэн (1).....улсыг байгуулжээ. Хятад хүмүүс Доаги (2) шашин суртлыг голлон шүтэж ирэв. X зууны эхний хагаст Хятадад (3) гаргаж сурчээ. Европт үүнээс 300 жилийн дараа хэрэглэж эхэлсэн юм.

1	2	3
a. Тан	a. Загалмайн	a. Дарь
b. Сүн	b. Күнз	b. Шаазан урлал
c. Сүй	c. Шинто	c. Торго

A. 1a, 2b, 3c

B. 1b, 2a, 3c

C. 1a, 2c, 3a

D. 1c, 2b, 3c

E. 1a, 2b, 3a

22. Энэтхэг улсын кастын тогтолцоог нийгэмд гүйцэтгэж буй үүргээр нь зөв тохируулна уу? (1 оноо)

1. Брахман

a. Санваартны үүргийг гүйцэтгэх

2. Шудра

b. Дээд давхаргынханд үйлчлэх

3. Вашяа

c. Удирдах, дайтах

4. Кшатра

d. Худалдаа, гар урлал, газар тариалан эрхлэх

A. 1d, 2c, 3a, 4b

B. 1a, 2c, 3d, 4b

C. 1a, 2b, 3d, 4c

D. 1a, 2b, 3c, 4d

E. 1d, 2b, 3a, 4c

23. Адилтгах замаар зөв хариултыг сонгоно уу. (1 оноо)

a. Баруун Европ–Рыцарь

b. Япон - ?

A. Катакана

B. Шинто

C. Харакири

D. Самурай

E. Ниппон

24. Ниругун овог хэнээс үүсэлтэй вэ? (1 оноо)

A. Алунгоо эхийн 3 хөвгүүн

B. Бөртэ чоно


C. Хабул

D. Добу мэргэн

E. Бодончар мунхаг



25. XII зууны газрын зурагт Монгол улсын газар нутгийг ямар тоогоор тэмдэглэсэн байна вэ?
(2 оноо)



A. 4 B.1 C. 2 D. 3 E. 5

26. Цэргийн жанждаас **Хубилай, Зэлмэ, Зэв, Сүбээдэй** нарыг Чингис хаан хэрхэн онцгойлон үнэлж нэрлэсэн бэ? (1 оноо)

A. Дөрвөн нохос B. Дөрвөн хүлэг C. Дархан D. Төрийн бэхи E. Түмтийн ноёд

27. Чингис хааны дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг зөв ялгасан хэсгийг сонгоно уу.

(1 OHOO)

1. Их Монгол улсыг байгуулав.
2. Евразийг дамнасан газар нутагт нэгдсэн дэг журам тогтоов.
3. Өрнө, дорнын улсуудын хооронд худалдаа, соёлын харилцаа хөгжив.
4. Хархорум хотыг байгуулах зарлиг бүүлгав.

A. 3, 4 B. 1, 2 C. 2, 3 D. 1, 4 E. 2, 4

28. Гүюг хаан 1247 онд Сүн улсыг эзлэх дайныг эхлүүлэв. Уг үйл явдал нь Чингисийн тооллын хэдэн онд болсон бэ? (1 оноо)

A. Чингисийн 58 он В. Чингисийн 85 он С. Чингисийн 41 он

D. Чингисийн 86 он

29. Өнөөгийн Иран, Ирак, Азербайжан, Армян, Гүрж, Турк, Афганистаны баруун хэсэг, Сирийн хойд хэсгийн нутаг дэвсгэрийг нэгтгэн захирч байсан Монголын эзэнт гүрний бүрэлдэхүүн улсыг сонгоно уу. (1 оноо)

A. Ил хаант улс В. Цагадайн улс С. Их Юань улс

D. Алтан Ордны улс Е. Их Монгол улс

30. Хүснэгтийг ажиглан Алтан Ордны улсад холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Түүхэн зүтгэлтэн	2. Он цаг	3. Соёлын ололт
a. Хүлэгү	a. 1271 он	a. Судрын чуулган
b. Бат	b. 1242 он	b. Кебек хааны зоос
c. Хубилай	c. 1221 он	c. Дөрвөлжин бичиг
d. Цагадай	d. 1256 он	d. Абдулла ноёны гэрэгэ

A. 1b, 2b, 3d B. 1b, 2d, 3a C. 1a, 2a, 3d D. 1c, 2b, 3c E. 1d, 2c, 3b



31. 1449 онд Ойрадын Эсэн тайш ямар улсын хааныг олзолсон бэ? (1 оноо)
 А. Төвөд В. Чусон С. Киргиз D. Орос Е. Мин
32. Дорнод Монголын баруун гурван түмнийг зөв сонгоно уу. (1 оноо)
 А. Ордос, Түмэд, Урианхай В. Халх, Урианхай, Цахар С. Цахар, Түмэд, Урианхай
 D. Дөрвөд, Урианхай, Торгууд Е. Ордос, Түмэд, Юншээбүү
33. XVII зууны Монголын бие даасан улсуудаас **1636 он, Очир Цагаан хот, Цахар** зэрэг ойлголтууд нь аль улсад холбогдох вэ? (1 оноо)
 А. Өвөр Монгол В. Халх Монгол С. Зүүнгар улс
 D. Хошууд улс Е. Хотгойд улс
34. Доорх өгөгдлийг зөв харгалзуулна уу. (2 оноо)
- | | |
|---------------|---|
| 1. Засагт хан | a. Хангайн нурууны бүс нутаг, Монгол Алтайн зарим хэсгээр |
| 2. Түшээт хан | b. Хэрлэн голын сав, Дорнод Монголын тал хээр нутаг |
| 3. Сэцэн хан | c. Туул голын хөндий, Орхон голын дээд бие, Тамирын голын сав газраар |
- А. 1с, 2b, 3a В. 1b, 2a, 3с С. 1a, 2с, 3b D. 1b, 2с, 3a Е. 1a, 2b, 3с
35. XVI зуунд Энэтхэг, Төвөд үгийг Монгол бичгээр галиглах зорилгоор хэн, ямар үсгийг зохиосон бэ? (1 оноо)
 А. Намхайжамц, тод В. Аюуш гүүш, али гали С. Занабазар, соёмбо
 D. Пагва лам, дөрвөлжин бичиг Е. Агваандорж, вагиндра
36. XIV-XVII зууны үеийн монголын уран зохиолд дотоодын дайн дажныг эсэргүүцсэн, нэгдэл нягтрал, энх амгалан амьдрал, сайн сайхныг мөрөөдөн уриалсан утга санаа голлосон зохиолууд гарч байв. Эдгээр бүтээлүүдээс аль нь хамаарах вэ? (1 оноо)
- | | | |
|-------------------------|-------------------------|-------------|
| 1. Жангар | 2. Монголын нууц товчоо | 3. Шар тууж |
| 4. Мандухай хатны домог | 5. Эрдэнийн товч | |
- А. 1, 5 В. 1, 2 С. 4, 5 D. 3, 4 Е. 1, 4
37. Халх, Ойрадын дайны уршгаар 1691 онд Халх Монголын ноёд чуулган хийж хаана, хэнд дагаар орсон бэ? (1 оноо)
 А. Долоон нуурт, Энх-Амгалан В. Мүгдэнд, Абахай С. Цахарт, Лигдэн
 D. Бээжинд, Нурхач Е. Ар элстэйд, Занабазар
38. Халимаг, Буриадын түүхэнд холбогдох үйл явдлуудыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (1 оноо)
1. Манж–Оросын хооронд Нэрчүгийн гэрээ байгуулав.
 2. Халимаг–Орос цэргийн холбооны гэрээ байгуулав.
 3. Халимагийн сүүлчийн их нүүдэл болов.
- А. 2, 1, 3 В. 3, 2, 1 С. 2, 3, 1 D. 1, 3, 2 Е. 1, 2, 3
39. Тайван төрөөр нэгтгэх бодлогыг ямар хаан хэрэгжүүлж байсан бэ? (1 оноо)
 А. Түмэн засагт хаан В. Галдан бошогт хаан С. Лигдэн хутагт хаан
 D. Батмөнх даян хаан Е. Түмэдийн Алтан хан



40. Монголчууд харийн эрхшээлд ороход нөлөөлсөн гадаад шалтгаан аль нь вэ? (1 оноо)
- A. Зүүнгар улс болон Халх Монгол хоорондоо эв түнжингүй байсан
 B. Монголын их хааны сүр хүч буурч, төвлөрсөн засаглал суларсан.
 C. Халхын баруун, зүүн гар хоорондоо дайсагнасан байдалтай байсан.
 D. Монголчууд Мин улстай худалдаа арилжаа хийж байсан.
 E. Манж улс хагалан бутаргах, эзлэн түрэмгийлэх бодлого явуулсан.

41. 1905 оны намар Жирэмийн чуулганы өмнөд Горлос хошуунд Тогтох тайжийн удирдлагаар бослого гарчээ. Энэхүү эсэргүүцэл нь тэмцлийн ямар хэлбэрт хамаарах вэ? (1 оноо)

- A. Заргын бичиг
 B. Алба хаях
 C. Зэвсэгт бослого
 D. Дугуйлангийн хөдөлгөөн
 E. Бөөнөөрөө оргон нүүх

42. Хүснэгтийг ажиглан Улиастайд гарсан бослогод холбогдох зөв хариултыг сонгоно уу. (2 оноо)

1. Түүхэн зүтгэлтэн	2. Он цаг	3. Цэргийн тоо
a. Ард Аюуш	a. 1900 он	a. 800
b. Чингүнжав	b. 1880 он	b. 247
c. Энхтайван	c. 1755 он	c. 2000

- A. 1c, 2c, 3b
 B. 1a, 2d, 3a
 C. 1c, 2a, 3b
 D. 1a, 2b, 3b
 E. 1c, 2a, 3c

43. Жил бүрийн 12-р сарын 29-ний өдрийг Монголчууд ямар өдөр хэмээн тэмдэглэдэг вэ? (1 оноо)

- A. Цэргийн баяр
 B. Тусгаар тогтнолоо сэргээн мандуулсан өдөр
 C. Эх орончдын өдөр
 D. Анхдугаар үндсэн хууль баталсан өдөр
 E. Монгол бахархлын өдөр

44. Богд хаант Монгол улсын үеийн **1914, дөрвөн анги, сургагч** зэрэг ойлголтууд нь ямар сургуулийг илэрхийлж байна вэ? (1 оноо)

- A. Орос хэл бичгийн сургууль
 B. Цэргийн сургууль
 C. Шашны сургууль
 D. Иргэний сургууль
 E. Албаны сургууль

45. 1921 онд хувьсгалчид хоорондоо 400-аад нууц түлхүүр үгээр харилцаж байсан бол доорх сурвалжид дурдагдаж буй Иван гэж хэн бэ? (1 оноо)

“Малын үнэ муу. Хээр морь эмгэгтэй Бутковоос янчаан авах төлөвтэй. Георгийгээр хүргүүлнэ. Мөнгөний явдалд яар. Мөнгөний хариу даруй өг Иван”. Үндэсний Төв Архивын баримтаас

- A. Х.Чойбалсан
 B. Д.Догсом
 C. Д.Чагдаржав
 D. С.Данзан
 E. Д.Бодоо

46. Ардын засгийн газрын үеийн **боловсролын** арга хэмжээнд хамаарах онцлох үйл явдлуудыг сонгоно уу. (2 оноо)

1. Тангаргийн гэрээг мөрдүүлэв.
2. Бага, дунд сургуулийн танхимын дүрэм батлав.
3. Улсын түр цагийн хурал байгуулав.
4. Үндэсний мөнгөн тэмдэгтэй болох алхам хийгдэв.
5. Судар бичгийн хүрээлэнг байгуулав.

- A. 2, 5
 B. 2, 4
 C. 1, 5
 D. 2, 3
 E. 4, 5



47. БНМАУ-ын анхдугаар үндсэн хуульд зааснаар аль нь төрийн дээд эрхийг барих вэ?

(1 оноо)

- A. Улс төрийн товчоо B. Ардын их хурал C. Сайд нарын зөвлөл
D. Улсын их хурал E. Улсын бага хурал

48. Цэгийн оронд тохирох хариултыг сонгоно уу.

(1 оноо)

Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр 1935 онд Монгол кино үйлдвэр байгуулагдаж, дараа жил нь анхны уран сайхны кино дэлгэцнээ гарав.

- A. Цогт тайж B. Ардын элч C. Нийслэл хүү D. Монгол хүү E. Зэрэг нэмэхийн өмнө

49. Өгөгдлийг зөв тохируулна уу.

(2 оноо)

- | | |
|---|-----------------------------|
| 1. Шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэв. | a. 1934 оны 3-р сарын 26 |
| 2. Аж үйлдвэрийн комбинат байгуулав. | b. 1934 оны 9-р сарын 1 |
| 3. Радио өргөн нэвтрүүлэг явуулж эхлэв. | c. 1932 оны 6-р сарын 29-30 |
| A. 1a, 2c, 3b B. 1c, 2b, 3a C. 1c, 2a, 3b D. 1b, 2c, 3a E. 1a, 2b, 3c | |

50. Тэгшитгэлийг ашиглаж зөв хариултыг сонгоно уу.

(1 оноо)

(Олноо өргөгдсөний 10 он+Ардын хувьсгалын 23 жилийн ой): $2+13=?$

- A. 1939 онд Халх голын дайн болов. B. 1959 онд Соёлын довтолгоо өрнөв.
C. 1945 онд Чөлөөлөх дайн болов. D. 1976 онд Атрын II аян өрнөв.
E. 1961 онд Монгол улс НҮБ-д элсэв.

51. Ю.Цэдэнбал “Монголын ард түмний амьдралд ач холбогдлоороо 1921 оны ардын хувьсгалтай тэнцэхүйц түүхэн үйл явдал” хэмээн эдийн засагт хийгдсэн ямар ажлыг дүгнэсэн бэ?

(1 оноо)

- A. Атрын аян B. Соёлын довтолгоо C. Нэгдэлжих хөдөлгөөн
D. Аж үйлдвэр, дэд бүтэц E. Эрчим хүч, барилга


52. Ямар түүхэн үйл явдлаар БНМАУ-д нэг намын ноёрхол эцэс болсон бэ?

(2 оноо)

- A. 1990 оны 2 сарын 18-нд Монголын ардчилсан намыг эмхлэн байгуулснаар
B. 1990 оны 3 сарын 12-14-нд болсон МАХН-ын бүгд хурлаар улс төрийн товчоо нарийн бичгийн дарга нарыг бүрэн бүрэлдэхүүнээр огцруулснаар
C. 1990 оны 3 сарын 9-ний оройн нам төрийн тэргүүн Ж.Батмөнх ард түмэндээ хандан радио, телевизээр орон даяар мэдээлэл хийснээр
D. 1990 оны 3 сарын 7-ны өдрийн 14 цагт МоАХ-ны 10 гишүүн Сүхбаатарын талбайд улс төрийн тэмцлийн хурц хэлбэр болох өлсгөлөн зарлан тэмцсэнээр
E. 1990 оны 3 сарын 22-24-нд хуралдсан АИХ-ын чуулган, МАХН бол “төр нийгмийг удирдан чиглүүлэгч цорын ганц хүчин мөн” гэсэн үндсэн хуулийг заалтыг хүчингүй болгосноор



53. Энэхүү диаграммд хэдэн оны ямар түүхэн үйл явдалтай холбоотой мэдээлэл агуулагдаж байна вэ? (2 оноо)




- A. 1997 оны ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн дүн мэдээ
 B. 2000 оны 7-р сарын 3-нд явагдсан УИХ-ын ээлжит сонгууль
 C. 1992 оны 6-р сард бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгуулийн дүн мэдээ
 D. 1996 оны 6-р сарын 30-нд явагдсан УИХ-ын сонгууль
 E. 1990 оны 7-р сарын 22-29-нд явагдсан олон намын ардчилсан сонгууль
54. 1990 оны хувьсгалаар оюун санааны хүрээнд гарсан ололтод холбогдох үйл явдлуудыг он цагийн хувьд зөв дараалалд оруулсныг сонгоно уу. (2 оноо)

1. Монголын нууц товчоо зохиогдсоны 750 жилийн ой болов.
 2. Монгол улсын түүх 5 боть хэвлэгдэв.
 3. Мэгжид Жанрайсиг шүтээнийг дахин сэргээн Гандантэгчинлэн хийдэд залав.
- A. 1, 2, 3 B. 3, 2, 1 C. 2, 3, 1 D. 1, 3, 2 E. 2, 1, 3

55. Ардчилсан хувьсгалын үр дүнд үндэсний үзэл, ухамсар сэргэснийг зөв илэрхийлсэн нь аль вэ? (2 оноо)

- A. Спортын салбарт тив, дэлхийн аваргууд олноор төрсөн.
 B. Төрт ёсны уламжлалт 9 хөлт цагаан тугаа хүндэтгэн залсан.
 C. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталсан.
 D. 1993 онд Бурхан багшийн чандрыг Монголд залсан.
 E. Электрон технологи бүтээж, цахим сүлжээ чөлөөтэй ашиглах болсон.

56. Он тооллын шугамыг ажиглан Монгол улсын гадаад харилцааны онцлог үйл явдлын түүхэн зүтгэлтэн, он цагийг зөв сонгоно уу. (2 оноо)



- A. 2014, Ши Жиньпин
 D. 1991, В.Путин

- B. 2014, В.Путин
 E. 2006, Сергей Лавров

- C. 2006, Жорж Буш



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо
Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

2.1 Дундад зууны Арабын түүхэнд холбогдох ойлголтуудыг тохируулахдаа 1-7 хүртэлх өгөгдлөөс сонгож зөв харгалзуулна уу. /1 өгөгдөл илүүг анхаарна уу/ (6 оноо)

- | | |
|----------------------|--|
| a. Аж ахуй | 1. Арабын хойг, хойд Африк |
| b. Мэдлэг, боловсрол | 2. Бичиг үсэг, анагаах ухаан |
| c. Хот суурин | 3. Альгамбрын ордон, Кордова хотын сүм |
| d. Түүхэн зүтгэлтэн | 4. Мусульман, Коран судар |
| e. Газар нутаг | 5. Усан үзэм, арвай тариалах |
| f. Шашин шүтлэг | 6. Медин, Мекка |
| | 7. Абу Бекр, Осман халиф |

2.2 Чингис хаантай холбогдох түүхэн үйл явдлуудыг эхлэлээс төгсгөл рүү он цагаар нь зөв эрэмбэлнэ үү. (6 оноо)

- | | |
|--|-------|
| a. Наху гүнд Таян ханы цэрэгтэй тулалдаж, Найман улсыг мөхөөв | |
| b. Жамуха Далан Балжудын тулаанд ялалт байгуулав | |
| c. Хэрэйдийн Тоорил хантай эцэг хөвгүүний харилцаа тогтоов | |
| d. Онон мөрний эхэнд их хуралдайгаар Чингис хааныг их сууринд залав | |
| e. Хубилай хааны зарлигаар ордны зураач Хорихосун Чингис хааны хөргийг зурав | |
| f. Хэрэйдийн Тоорил хантай хамтран татаруудыг Улз голд бут цохив | |

2.3 БНМАУ-ын нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтийг холбогдох үйл явдлуудтай нь зөв харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|---------------------------|---|
| a. Нэгдэлжих хөдөлгөөн | 1. Баруунтны бодлогыг сэргээн хэрэгжүүлсэн |
| b. Соёлын довтолгоо | 2. Малын тоог хангайд 50, говьд 75 толгойгоор тогтоосон |
| c. Шинэ эргэлтийн бодлого | 3. Намын эсрэг харш үг өгүүлэл, шүүмжлэл гарсан |
| d. Атрын аян | 4. Иргэншсэн ертөнцийн ахуйн соёл хэвшин тогтсон |
| e. Аж үйлдвэр, дэд бүтэц | 5. Хэрэглэгч орноос үйлдвэрлэгч орон болсон |
| f. Сэхээтний төөрөгдөл | 6. Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр байгуулсан |

2.4 БНМАУ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын хөгжилд холбогдох үйл явдлуудыг түүхэн зүтгэлтнүүдтэй нь харгалзуулна уу. (6 оноо)

- | | |
|--|----------------|
| a. Монгол хүн сансарт нисэв | 1. Ж.Мөнхбат |
| b. Олимпоос анхны мөнгө медалийг хүртэв | 2. Д.Чоймбол |
| c. Сүхбаатарын хөшөөг урлав | 3. Ж.Гүррагчаа |
| d. Малын вакцин бүтээв | 4. Д.Дашдаваа |
| e. Харанхуй засаг жүжгийн зохиолыг бичив | 5. Б.Ширэндэв |
| f. Шинжлэх ухааны академи байгуулав | 6. С.Буяннэмэх |

